



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/459

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Орос хэлний лингафоны сургалтын танхимын тоног төхөөрөмж нийлүүлэх" ажлыг гүйцэтгэгч "Төгс шимт оргил" ХХК-ын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Ц.Ганданповрон

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн  
хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Р.Давааханд

-Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн багш

П.Амгаланбаатар

- Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн  
нягтлан бодогч

Д.Гантуяа

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн

дарга: Н.Цолмон

- Аймгийн Орон нутгийн өмчийн газрын  
мэргэжилтэн

2."Орос хэлний лингафоны сургалтын танхимын тоног төхөөрөмж нийлүүлэх" ажлыг гүйцэтгэгч "Төгс шимт оргил" ХХК-ний ажлыг техникийн тодорхололт, ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/459 Ch  
02 02274